



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 01

Ховд

“Улсын сайн малчин”-д тодорхойлох  
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын сайн малчин” шалгаруулах журмыг удирдлага болгон аймгийн Засаг даргын оруулсан саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Улсын сайн малчин” шалгаруулах журмын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан Цэцэг сумын Хажинга багийн малчин Авид овогтой Амархүү, Чандмань сумын Баянхайрхан багийн малчин Чойжилсүрэн овогтой Батдорж, Мөнххайрхан сумын Хаг багийн малчин Чоймбол овогтой Оюун, Буянт сумын Цагаанбургас багийн малчин Мөнхсүлд овогтой Энх-Амгалан, Манхан сумын Тахилт багийн малчин Дондог овогтой Амгаланбаатар нарыг “Улсын сайн малчин” цол, шагнал олгуулахаар тодорхойлсныг дэмжсүгэй.

2.“Улсын сайн малчин”-аар тодорхойлогдож байгаа дээрх малчдын тодорхойлолт, холбогдох баталгаажсан материалыг Хөдөө аж ахуйн яамны Улсын сайн малчин цол олгох комисст уламжилж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 02

Ховд

“Улсын тэргүүний тариаланч”-аар  
тодорхойлох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын тэргүүний тариаланч” шалгаруулах журмыг удирдлага болгон аймгийн Засаг даргын оруулсан саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Улсын тэргүүний тариаланч” шалгаруулах журмын шалгуур үзүүлэлтийг бүрэн биелүүлсэн Ховд сумын Улаанбураа багийн тариаланч Сейтхан овогтой Наскейн, Жаргалант сумын Хайрхан багийн тариаланч Лхамсүрэн овогтой Цэцэгсүрэн, Буянт сумын Норжинхайрхан багийн тариаланч Төлөөгөн овогтой Нурлан нарыг “Улсын тэргүүний тариаланч” цол, шагнал олгуулахаар тодорхойлсныг дэмжсүгэй.

2. “Улсын тэргүүний тариаланч”-аар тодорхойлогдож байгаа дээрх тариаланчдын тодорхойлолт, холбогдох баталгаажсан материалыг Хөдөө аж ахуйн яамны Улсын тэргүүний тариаланч цол олгох комисст уламжилж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 03

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Монгол улсын Гавъяат багш цол”-оор

1. Гэндэнжав Нямдаваа - Жаргалант сумын Жаргалан багийн иргэн

“Хөдөлмөрийн Гавъяаны Улаан Тугийн одон”-гоор

1. Цэрэндорж Отгонбаатар - Эрдэнэбүрэн сумын Засаг дарга  
2. Норжмаа Бадрах - Алтайн буйлааст ХХК-ний захирал

“Алтан гадас одон”-гоор

1. Баасанхүү Амаржаргал - БОЭТ-ийн дотрын тасгийн их эмч  
2. Морх Амарсанаа - Аймгийн Засаг даргын орлогч дарга  
3. Өлзийбаяр Түвдэндорж - Баруун Монгол интернэйшнил ХХК-ний захирал  
4. Нямхүү Энхмандах - Ховд Эрч хүч ОНӨААТҮГ-ын дарга  
5. Батмэнд Мөнхбаяр - Булган баян буудай ХХК-ний захирал

- |                    |   |
|--------------------|---|
| 6. Энхээ Уртнасан  | - Үенч сумын Засаг дарга                          |
| 7. Жамъян Төмөрбат | - Мөст сумын Баянхайрхан багийн иргэн             |
| 8. Бат Жавзмаа     | - Жаргалант сумын Жаргалан багийн<br>ахмад настан |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

- |                          |  |
|--------------------------|--|
| 1. Жигжидсүрэн Батсайхан | - Аймгийн Буянт ноос ХХК-ний захирал   |
| 2. Эрдэнэ Өлзийхүү       | - Хан Жаргалант хоршооны дарга         |
| 3. Батхүү Хатанзориг     | - Алтайн өрөм ХХК-ний захирал          |
| 4. Хөвөш Харахат         | - Шим-Ус ОНӨҮГ-ын орлогч дарга         |
| 5. Галаа Жаргал          | - ХИС-ийн санхүүгийн албаны дарга      |
| 6. Баяраа Бат-Энэрэл     | - Аймгийн Ардчилсан намын ХЭГ-ын дарга |
| 7. Ахыт Арбол            | - Ховд сумын Засаг даргын орлогч дарга |

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 04

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг хагас бүтэн жилээр тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 05

Ховд

Нэгдсэн төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2016 онд нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдөр, сум, байгууллагын ой, спорт, урлагийн арга хэмжээ, сургалт семинар, зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Нийтээр тэмдэглэх баяр, ой, тэмдэглэлт өдрүүдийг салбар байгууллагын хэмжээнд бүтээн байгуулалтын ажил өрнүүлж, тэмдэглэн өнгөрүүлэх, урлаг спорт, соёл урлагийн арга хэмжээнүүдийг төлөвлөсөн хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг сум, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Нэгдсэн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тухайн жилийн 12 дугаар сарын 01-ны дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Батмөнх/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 06

Ховд


Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал, 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгал, 1939 оны Халх голын дайн, 1945 оны чөлөөлөх дайн, 1946-1948 оны Баруун хилийн тулгаралтад гар бие оролцож, Монгол улсынхаа тусгаар тогтнол, үндэсний эрх чөлөөний төлөө баатарлагаар тэмцэж, эх орныхоо хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтанд бодит хувь нэмэр оруулан, бүс нутгийн хөгжлийн тулгуур болон эрчимтэй хөгжиж, олон угсаатны бүлгүүдийн уламжлалт ёс заншил, иргэдийнхээ оюуны чадавх, бүтээлч хөдөлмөрийг өрнүүлэн “Хүн амьдрах таатай орчинтой, үйлдвэрлэл, бизнест ээлтэй, ногоон хөгжлийн загвар аймаг” болох зорилтыг тавьж, хөдөлмөрлөж байгаа “Ардчилалын өлгий нутаг” Ховд аймгийн түүхэн баатарлаг замнал, улс эх орон, бүс нутгийн хөгжил, цэцэглэлтэд оруулсан хувь нэмэр, хөдөлмөрч уламжлал, ажлын үр дүнг үнэлж, төрийн дээд шагнал “Сүхбаатарын одон”-гоор шагнуулахаар Монгол улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

2. Ховд аймгийг Төрийн дээд шагнал “Сүхбаатарын одон”-д тодорхойлсон баримт бичгүүдийг холбогдох журмын дагуу бүрдүүлж Монгол улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт 2016 оны 02 дугаар сарын 01-ний дотор багтаан хүргүүлэхийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 07

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Монгол улсын Гавъяат малчин цол”-оор

1. Цэрэннадмид Насанжаргал - Эрдэнэбүрэн сумын малчин

“Алтан гадас одон”-гоор

1. Чимхүү Бат-Эрдэнэ - Аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч
2. Зодов Мөнхжаргал - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын Статистикийн мэргэжилтэн
3. Банзрай Нямдорж - Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын жолооч
4. Даваадорж Эрдэнэчимэг - Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын ЭАХХХ-ын улсын байцаагч

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

1. Мөнхбаяр Лхагвасүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч



2. Жанжаа Дэнсмаа

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
үйлчлэгч

3. Баасай Энхтөр

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
жолооч

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 08

Ховд

Сонгуулийн тойрог байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5, Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 16 дугаар зүйлийн 16.2, 22 дугаар зүйлийн 22.1, 22.6, 22.8 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ыг сонгох олонхийн сонгуулийн тойргийг сонгуулийн тогтолцоо, сонгогчдын тоотой уялдуулан Ховд аймгийн Жаргалант сумын баг болон аймгийн бусад сум тус бүрийг сонгуулийн тойрог болгон дугаарлаж, нийт 28 тойргийг байгуулж хавсралтаар баталсугай.

2. Аймгийн ИТХ-ыг сонгох сонгуулийн тойрог байгуулсан тухай нийтэд мэдээлэн сурталчилж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



Аймгийн ИТХ-ын Тэргүүдэгчдийн  
2016 оны 08 дугаар тогтоолын  
хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫГ СОНГОХ  
ОЛОНХИЙН СОНГУУЛИЙН ТОЙРОГ

Тойргийн дугаар	Сонгуулийн тойргийн нэр
1	Аймгийн ИТХ-ыг сонгох Алтай сумын сонгуулийн тойрог
2	Аймгийн ИТХ-ыг сонгох Булган сумын сонгуулийн тойрог
3	Аймгийн ИТХ-ыг сонгох Буянт сумын сонгуулийн тойрог
4	Аймгийн ИТХ-ыг сонгох Дарви сумын сонгуулийн тойрог
5	Аймгийн ИТХ-ыг сонгох Дөргөн сумын сонгуулийн тойрог
6	Аймгийн ИТХ-ыг сонгох Дуут сумын сонгуулийн тойрог
7	Аймгийн ИТХ-ыг сонгох Зэрэг сумын сонгуулийн тойрог
8	Аймгийн ИТХ-ыг сонгох Манхан сумын сонгуулийн тойрог
9	Аймгийн ИТХ-ыг сонгох Мөнххайрхан сумын сонгуулийн тойрог
10	Аймгийн ИТХ-ыг сонгох Мөст сумын сонгуулийн тойрог
11	Аймгийн ИТХ-ыг сонгох Мянгад сумын сонгуулийн тойрог
12	Аймгийн ИТХ-ыг сонгох Үенч сумын сонгуулийн тойрог
13	Аймгийн ИТХ-ыг сонгох Ховд сумын сонгуулийн тойрог
14	Аймгийн ИТХ-ыг сонгох Цэцэг сумын сонгуулийн тойрог
15	Аймгийн ИТХ-ыг сонгох Чандмань сумын сонгуулийн тойрог
16	Аймгийн ИТХ-ыг сонгох Эрдэнэбүрэн сумын сонгуулийн тойрог
17	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Алагтолгой багийн сонгуулийн тойрог
18	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Баатархайрхан багийн сонгуулийн тойрог
19	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Бичигт багийн сонгуулийн тойрог
20	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Бугат багийн сонгуулийн тойрог
21	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Буянт багийн сонгуулийн тойрог
22	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Жаргалан багийн сонгуулийн тойрог
23	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Магсаржав багийн сонгуулийн тойрог
24	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Наран багийн сонгуулийн тойрог
25	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Рашаант багийн сонгуулийн тойрог
26	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Тахилт багийн сонгуулийн тойрог

27	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Хайрхан багийн сонгуулийн тойрог
28	Аймгийн ИТХ-ыг сонгох Жаргалант сумын Цамбагарав багийн сонгуулийн тойрог

---oOo---



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 10

Ховд

Эмчилгээний зардалд дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймаг дахь Нисэх буудлын дарга Х.Отгонбаатар нь магадлан итгэмжлэл бүхий Хавдар судлалын Үндэсний төв эмнэлгийн шийдвэрээр Энэтхэг улсад элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэж, эмчлүүлэх шаардлагатай болсон тул эмчилгээний зардалд 5.0 сая төгрөг /таван сая/-ийн нэг удаагийн тусламж дэмжлэг үзүүлсүгэй.

2. Х.Отгонбаатарын эмчилгээний зардалд олгох 5.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2016 оны батлагдсан нөөц хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 11

Ховд


Эмчилгээний зардалд дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Хөгжимт драмын театрын дуучин Б.Мэндээ нь нүдний хараа сэргээх мэс засал хийлгэж, эмчлүүлэх шаардлагатай болсон тул эмчилгээний зардалд 3.0 сая төгрөг /гурван сая/-ийн нэг удаагийн тусламж дэмжлэг үзүүлсүгэй.

2. Б.Мэндээгийн эмчилгээний зардалд олгох 3.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2016 оны батлагдсан нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 12

Ховд

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, Ховд сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн 2016 оны 31 тоот хүсэлт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний боломжийг бүрдүүлэх шаардлагыг харгалзан аймгийн төсвийн 2015 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар БОЭТөвд олгосон Уаз-Хантерь ГСУАЗ 29892 маркийн 2014 оны 05 дугаар сарын 07-нд ОХУ-д үйлдвэрлэсэн, 2015 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр Монгол улсад орж ирсэн, 2015 оны 05 дугаар сарын 20-ний өдөр ашиглалтанд орсон, моторын 315100E0597322, арлын 315140E1005838 дугаартай, хар өнгийн, улсын дугааргүй 28000.0 төгрөг /хорин найман сая/-ийн үнэтэй суудлын автомашиныг Ховд сумын Эрүүл мэндийн төвд, Эрүүл мэнд, спортын сайдын төсвийн багцийн хөрөнгө оруулалтаар Ховд сумын Эрүүл мэндийн төвд олгосон NISSAN X-Trail маркийн, 2015 онд Япон улсад үйлдвэрлэсэн, 2015 оны 12 дугаар сарын 30-ний өдөр Монгол улсад орж ирсэн, 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ашиглалтанд орсон, арлын JN1JBNF32Z0004542 дугаартай, цагаан өнгөтэй, ХОУ 4594 улсын дугаартай, 69400,0 төгрөг /жаран есөн сая дөрвөн зуун мянга/-ийн үнэтэй суудлын автомашиныг аймгийн БОЭТөвд тус тус шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Байгууллагаас ажлын хэсгийг томилж, автомашиныг зохих журмын дагуу хүлээлцэн данс бүртгэлд тусгаж ашиглалтыг хариуцаж ажиллахыг аймгийн БОЭТ-ийн

захирал /Т.Баяртогтох/, Ховд сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /Н.Бэрхбол/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, хөдлөл өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 13

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Монгол улсын Гавъяат хуульч цол”-оор

1. Цэдэн Даваасүрэн - Аймгийн өмгөөллийн товчооны өмгөөлөгч

“Монгол улсын Гавъяат эдийн засагч цол”-оор

1. Лханаа Галбадрах - Аймгийн Аудитын газрын дарга

“Алтан гадас одон”-гоор

1. Лэгцэг Пида - Буянт сумын Наранхайрхан багийн малчин
2. Цэдэн Загдсүрэн - Буянт сумын Наранхайрхан багийн малчин
3. Банзрай Тогтох - Жаргалант сумын Баатархайрхан багийн ахмад настан
4. Сонинтөр Жимсээ - Мөнххайрхан сумын Сэнхэр багийн ахмад настан
5. Галсан Лхамжав - Эрдэнэбүрэн сумын Шураг багийн малчин
6. Чогзол Шагдарсүрэн - Дөргөн сумын Аргалант багийн ахмад настан
7. Батнасан Батсүх - ЭХБУ-ын “Исэт” ХХК-ний захирал

- |                       |   |
|-----------------------|---|
| 8. Лхайсүрэн Гантөмөр | - “Ховдын Хаш Өргөө” ХХК-ны өрлөгчин                        |
| 9. Цэрнээ Батзориг    | - Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн<br>мэргэжилтэн               |
| 10. Загд Виктор       | - Ховд аймаг дахь Бодь даатгал ХХК-д<br>даатгалын төлөөлөгч |
| 11. Ауганбай Күлиза   | - Аймгийн ЗДТГ-ын нийтлэг<br>үйлчилгээний албаны үйлчлэгч   |
| 12. Сурмаа Цэвэлмаа   | - 12 жилийн 2 дугаар сургуулийн<br>физикийн багш            |
| 13. Жамбал Балжинням  | - Жаргалант сумын Баатархайрхан<br>багийн ахмад настан      |
| 14. Чирчинжав Баярлах | - Буянт сумын ЗДТГ-ын архив, бичиг<br>хэргийн эрхлэгч       |
| 15. Найдан Бааст      | - Зэрэг сумын Бураа багийн ахмад настан                     |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

- |                          |   |
|--------------------------|---|
| 1. Ёндон Дулмаа          | - Жаргалант сумын Наран багийн ахмад настан         |
| 2. Жавсрай Загджав       | - Жаргалант сумын Наран багийн ахмад настан         |
| 3. Эрэн Даваасүрэн       | - Жаргалант сумын Наран багийн ахмад настан         |
| 4. Сэнгээ Гунгаа         | - Мянгад сумын Баянхошуу багийн ахмад настан        |
| 5. Аюурзана Цагаач       | - Мянгад сумын Баянхошуу багийн ахмад настан        |
| 6. Ням Намжилмаа         | - Дөргөн сумын Аргалант багийн ахмад настан         |
| 7. Дүнгүү Дэмбээ         | - Дөргөн сумын Сээр багийн ахмад настан             |
| 8. Окоо Цэвэлмаа         | - Дөргөн сумын Агваш багийн ахмад настан            |
| 9. Дэчин Отгонбаяр       | - Мөнххайрхан сумын Сэнхэр багийн ахмад<br>настан   |
| 10. Цэрэнчимэд Дорждэрэм | - ЭХБУ-ын “Исэт” ХХК-ний ерөнхий инженер            |
| 11. Дэмбэрэл Баттулга    | - “Ховдын Хаш Өргөө” ХХК-ний бригадын дарга         |
| 12. Баруш Давааням       | - “Ховдын Хаш Өргөө” ХХК-ний мужаан                 |
| 13. Доржсүрэн Сэлмаа     | - “Ховдын Хаш Өргөө” ХХК-ний засал чимэглэлч        |
| 14. Ламсан Данзансүрэн   | - Манхан сумын ЗДТГ-ын БОХУБайцаагч                 |
| 15. Лааж Дэнсмаа         | - Үенч сумын Засаг даргын Тамгын газрын<br>үйлчлэгч |
| 16. Дорж Мөнхдалай       | - Үенч сумын БОХУБайцаагч                           |
| 17. Гаябазар Пүрэвдорж   | - ХИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч                 |

- |                          |   |
|--------------------------|---|
| 18. Багабанди Цэрэндаваа | - ХИС-ийн НХУС-ийн захирал                              |
| 19. Дорж Оюунцэцэг       | - Үенч сумын 12 жилийн сургуулийн<br>Гадаад хэлний багш |
| 20. Самдан Вандан        | - Буянт сумын Наранхайрхан багийн<br>ахмад настан       |

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 14

Ховд

Дахин нийтийн дуудлагын худалдаа  
зарлах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэхь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийтийн дуудлага худалдааг дахин зарлаж худалдах хөрөнгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, үнийг нь бууруулж дахин нийтийн худалдаа зарлаж худалдах хөрөнгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай. .

2. Тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан хөрөнгийн нийтийн дуудлага худалдааг 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдөр аймгийн Нутгийн удирдлагын ордонд, 2 дугаар хавсралтаар баталсан хөрөнгийн нийтийн дуудлагын худалдааг 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Ховд сумын Засаг даргын Тамгын газрын байранд тус тус зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан, борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны  
 ..... дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

НИЙТИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/мянган төгрөгөөр/

Д/д	Эзэмшигч байгууллага	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Үлсвэр дугаар	Өнгө	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Дуудлагын худалдааны доод үнэ
1	Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар	Hyundai Grace Микро	2012	1424 ХОУ	Хөх ягаан	11950,0	5975,0	5975,0	5975,0
2	Аймгийн Цагдаагийн газар	Верна аксент	2010	6699ХОА	Хөх алаг	5500,0	5465,3	34,7	150,0



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны  
 11 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ХОВД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НЙТИЙН ДУУДЛАГА  
 ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

Д/д	Эзэмшигч байгууллага	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон но	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ, төг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Дуудлагын худалдааны доод үнэ	
1	Ховд сумын Засаг даргын Тамгын газар	Баруун салаа багийн хуучин конторын барилга	2004	ш	1	2277.0	2277.0	695.8	1581.2	800,0	
2	Ховд сумын Засаг даргын Тамгын газар	Халуун ус /Сансарын дэнжид/	2003	ш	1	1081.6	1081.6	649.0	432.6	250,0	
3	Ховд сумын Засаг даргын Тамгын газар	Халуун ус /Бичигтийн гудамжинд/	2004	ш	1	1081.6	1081.6	594.9	486.7	260,0	
<b>НИЙТ ДҮН</b>							<b>4440.2</b>	<b>4440.2</b>	<b>1939.7</b>	<b>2500.5</b>	<b>1310,0</b>



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 15

Ховд

Олон нийтийн цагдаагийн ажилтны  
тоо тогтоох тухай

Монгол улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Засаг дарга, Иргэний зөвлөлөөс ирүүлсэн саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах ажилд олон нийтийн оролцоог дээшлүүлэх зорилгоор олон нийтийн цагдаагийн ажилтныг Булган, Буянт, Жаргалант, Манхан суманд тус бүр 2, бусад суманд тус бүр 1, аймгийн хэмжээнд 21 хүртэл ажилтан ажиллуулахаар тогтоосугай.

2. Цагдаагийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр Олон нийтийн цагдаагийн ажилтнуудыг томилж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр урамшуулан, ажлын үр дүнг нь жил бүрийн 12 дугаар сард дүгнэж ажиллахыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Түмэнжаргал/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 29 өдөр

Дугаар 16

Ховд

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
төлөөлөгчдийн тоог тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Сонгуулийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 152 дугаар зүйлийн 152.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймаг, орон нутгийн хүн амын нягтрал, нутаг дэвсгэрийн байршил, засаг захиргааны нэгжийн бүтцийг харгалзан Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал 41 төлөөлөгчтэй байхаар тогтоосугай.

2. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн тоог тогтоосон тухай нийтэд мэдээлэн сурталчилж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 29 өдөр

Дугаар 17

Ховд

Нэгдсэн төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2016 онд нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдөр, сум, байгууллагын ой, спорт, урлагийн арга хэмжээ, сургалт семинар, зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөөний 2 дугаар бүлгийн 2.6-д “Нэрт яруу найрагч, Буянт сумын уугуул Лувсангийн Дагвадоржийн 80 насны ойг 2016 оны 09 дүгээр сарын 09,10-ний өдрүүдэд тэмдэглэх” гэж нэмэлт оруулсугай.

2. Нэрт яруу найрагчийн 80 насны ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг байгуулан, соёл урлагийн хэмжээнүүдийг төлөвлөж, дурсгалыг нь мөнхжүүлэх ажил зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д даалгаж, Буянт сумын ИТХ-ын дарга /Н.Батдорж/-д зөвлөсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 29 өдөр

Дугаар 18

Ховд

Төсөв батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн “в” заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хөшөөт хөгжил сан”-гийн журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3, 4.2.9 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Ховд Хөшөөт хөгжил сан”-гийн 2016 оны төсөв, санхүүгийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсвийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг сангийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Б.Баярсайхан/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 29 өдөр

Дугаар 19

Ховд

Нийтийн дуудлага худалдаа зарлах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд, Мөнххайрхан сумдын Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй, суудлын автомашинуудыг нийтийн дуудлага худалдаагаар худалдах доод үнийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн дуудлага худалдаагаар худалдах автомашины худалдааг 2016 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр аймгийн Нутгийн удирдлагын ордонд зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах автомашинуудыг зохих журмын дагуу дуудлагын худалдаагаар худалдаж, худалдан авагчид шилжүүлэн хүлээлгэн өгснөөр данс бүртгэлээс хасахыг Ховд, Мөнххайрхан сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

4. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт

тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг,  
үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны  
19 дүгээр тогтоолын хавсралт

НИЙТИЙН ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Худалдах хөрөнгийн марк	Ашиглалтанд орсон он	Ашигласан жил	Улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өртөг	Нийтийн дуудлага худалдаагаар худалдах доод үнэ
1	Ховд сумын эрүүл мэндийн төв	УАЗ-315122	2008	8	34-94ХОА	13800,0	13800,0	0,0	1000,0
2	Мөнххайрхан сумын ЭМТ	УАЗ-315122	2009,10	6,2	39-19ХОА	12500,0	12500,0	0,0	1500,0

---oOo---



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 29 өдөр

Дугаар 20

Ховд

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны Хөрөнгө шилжүүлэх тухай 68 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

2. Тус тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын балансад шилжүүлэн бүртгэсэн, 1996 онд үйлдвэрлэсэн, 2007 онд Монгол улсад орж ирсэн Land Cruiser 80 маркийн ХОА 44-55 улсын дугаар бүхий 20,0 сая төгрөгийн бүртгэлийн үнэтэй, ашиглалтын хугацаанд анхны үнийг элэгдлээрээ бүрэн нөхсөн суудлын автомашиныг аймгийн Засаг даргын Тамгын газрын балансаас хасч аймгийн Худалдан авах ажиллагааны хэлтсийн балансад бүртгэхээр шилжүүлсүгэй.

2. Байгууллагаас хөрөнгийг хүлээлцүүлэх ажлын хэсгийг томилж зохих журмын дагуу хүлээлцүүлэн хөрөнгийг бүртгэлээс хасахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Батмөнх/-д зөвшөөрч, хөрөнгийг хүлээн авах комиссыг томилон бүртгэлд авч, ашиглалтыг хариуцаж ажиллахыг ХАА-ны хэлтсийн дарга /Г.Мөнхжаргал/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлт, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 29 өдөр

Дугаар 21

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн "к", 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Мянган угалзат" ОНӨААТҮГ-ын 2016 оны үйл ажиллагааны орлогын доод хязгаарыг 187.0 сая төгрөг, зарлагын дээд хязгаарыг 184.1 сая төгрөг, цалингийн санг 78.9 сая төгрөг, ашгийг 2.9 сая төгрөг байхаар тус тус баталсугай.

2. "Мянган угалзат" ОНӨААТҮГ-ын 2016 оны үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөөг зохих журмын дагуу салбар нэгж, зардлын ангилал бүрээр хуваарилан баталж мөрдүүлэн, биелэлтэнд тухай бүр хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Д.Хуягбаатар/-д, байгууллагын орлогыг нэмэгдүүлэн хөрөнгө, санхүүгийн үр ашгийг дээшлүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал /Я.Мөнхтүвшин/-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 02 сарын 29 өдөр

Дугаар 22

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Монгол улсын Гавъяат багш цол”-оор

1. Рааш Тариа - Булган сумын өндөр настан

“Монгол улсын Гавъяат малчин цол”-оор

1. Мауитхан Насивхан - Ховд сумын Цагаан бургас багийн малчин

“Монгол улсын Гавъяат механикжуулагч цол”-оор

1. Рахмаан Хаугажай - Буянт сумын Норжинхайрхан багийн ахмад настан

“Монгол улсын Гавъяат холбоочин цол”-оор

1. Дамдинсүрэн Сонин - Аймгийн Холбооны газрын ахмад ажилтан

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор

1. Иса Акий - Буянт сумын Норжинхайрхан багийн өндөр настан  
2. Гаамаа Даваадорж - “ОДЦЭ” ХХК Тоосгоны үйлдвэрийн захирал



“Алтан гадас одон”-гоор

- |                          |   |
|--------------------------|---|
| 1. Харахман Жаналхан     | - Буянт сумын Норжинхайрхан багийн<br>өндөр настан                        |
| 2. Цагаадай Идэш         | - Мөст сумын Улаантолгой багийн<br>өндөр настан                           |
| 3. Чойжав Эвэлхүү        | - Жаргалант сумын Магсаржав багийн<br>иргэн                               |
| 4. Жавзан Цэвлээ         | - Жаргалант сумын Наран багийн<br>ахмад настан                            |
| 5. Чимгээ Цэрэндорж      | - Аймгийн Цагдаагийн газрын ахмад<br>ажилтан                              |
| 6. Жумба Пүрэвжамц       | - Дарви сумын Мөрөн багийн ахмад настан                                   |
| 7. Түдэв Лодон           | - Дарви сумын Баянбулаг багийн ахмад<br>настан                            |
| 8. Лхамхүү Мөнхнасан     | - Дуут сумын Босго багийн иргэн   |
| 9. Гэндэн Дэнсмаа        | - Жаргалант сумын Бичигт багийн<br>ахмад настан                           |
| 10. Тастаган Солтаншарав | - Ховд сумын Дунд ус багийн Засаг дарга                                   |
| 11. Ядмаа Буянтогтох     | - Нийгмийн Халамж үйлчилгээний<br>хэлтэс, Захиргаа, Хяналтын албаны дарга |
| 12. Кажекбер Ховдбай     | - Буянт сумын Цагаан-эрэг багийн малчин                                   |
| 13. Хохан Хойшыбай       | - Буянт сумын Норжинхайрхан багийн<br>ахмад настан                        |
| 14. Содмоо Ганхуяг       | - Аймгийн ССАЖГ-ын жудо, самбо<br>бөхийн дасгалжуулагч                    |
| 15. Даваадорж Бямбасүрэн | - БОЭТ-ийн Хүүхдийн тасгийн сувилагч                                      |
| 16. Цэвээндорж Баттулга  | - Мөст сумын ЗДТГ-ын Санхүүгийн<br>албаны дарга                           |
| 17. Баарай Батсайхан     | - Жаргалант сумын Тахилт багийн иргэн                                     |
| 18. Дамчаа Маамбаа       | - Мөнххайрхан сумын Цахилгаан Түгээх<br>Сүлжээ салбарт байцаагч           |
| 19. Дүгэр Муужаа         | - Булган сумын Далт багийн ахмад настан                                   |
| 20. Цэнд Батсүрэн        | - Алтайн буйлааст ХХК-ний засал<br>чимэглэлчин                            |
| 21. Жигжидсүрэн Нямсүрэн | - Хөшөөтийн уурхайн ажилчдын<br>автобусны жолооч                          |

- |                  |  |
|------------------|--|
| 22. Өнөр Энхболд | - “Цагаан бөлбөө” ХХК-ний захирал              |
| 23. Бэлэл Үсэв   | - Жаргалант сумын Наран багийн ахмад<br>настан |

“Цэргийн хүндэт медаль”-иар

- |                         |  |
|-------------------------|--|
| 1. Батсүх Ганзориг      | - Аймгийн Цагдаагийн газрын<br>ОНАБХТ-ын дарга                   |
| 2. Мэндээ Ганболд       | - Аймгийн Цагдаагийн газрын Замын<br>цагдаагийн тасгийн дарга    |
| 3. Дашзэвэг Зандмаа     | - Аймгийн Цагдаагийн газрын Мэдээлэл<br>судалгааны ахлах ажилтан |
| 4. Рагва Отгонжаргал    | - Аймгийн Цагдаагийн газрын Ахлах хэрэг<br>бүртгэгч              |
| 5. Сандуйжав Бямбасүрэн | - Аймгийн Цагдаагийн газрын Жижүүрийн<br>оффицер                 |
| 6. Батхүү Ганбаатар     | - Аймгийн Цагдаагийн газрын Мянгад сум<br>дахь ЦТ-т зохицуулагч  |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

- |                       |   |
|-----------------------|---|
| 1. Лхамжав Төмөрхуяг  | - Дулааны “Бадамлах Дөл” ХХК-ний<br>ашиглалтын инженер            |
| 2. Хулганаа Нэргүй    | - Дулааны “Бадамлах Дөл” ХХК-ний<br>лаборант                      |
| 3. Байдолда Бибигүл   | - Ховд сумын ЗДТГ-ын Архив, бичиг<br>хэргийн эрхлэгч              |
| 4. Пүрэвжав Дулмаахүү | - Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн<br>архив бичиг хэргийн эрхлэгч |
| 5. Нанжид Ганболд     | - Алтай сумын Барлаг багийн малчин                                |
| 6. Аврай Ескермес     | - Ховд сумын Цагаанбургас багийн<br>малчин                        |
| 7. Баатар Нямпүрэв    | - Вестерн Холд ХХК-ний кранист                                    |
| 8. Нина Тунгалагтамир | - Ховдын Өргөө ХХК-ний цахилгаанчин                               |
| 9. Цэдэв Цэцэгмаа     | - “ОДЦЭ” ХХК Тоосгоны үйлдвэрийн<br>орлогч захирал                |

ХУРЛЫН ДАРГА  Б. БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 23

Ховд

Хуралдаан зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "б", 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4, Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 64 дүгээр зүйлийн 64.1.2, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Ээлжит бус хуралдааныг 2016 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Ховд хотод хуралдуулж дараахь асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1/. Шинэ суурьшлын бүсэд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг дарга Д.Цэвээнравдан

2/. Аймгийн 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай

Илтгэгч нь: Аймгийн ГХБХБГ-ын дарга Д.Нямтулга

3/. Аймгийн 2016 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн П.Амгаланбаатар

2. Хуралдааны бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган, биелэлтийг хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Н.Бөхболд/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 24

Ховд

Сонгон шалгаруулалт зарлаж, гэрээ байгуулах  
зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн концессын гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан концессыг гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалтыг 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс нээлттэй зарлаж, шалгарсан аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны  
... дүгээр тогтоолын хавсралт



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

№	Концессын зүйлийн жагсаалт	Концессын зүйлийн төрөл	Концессын зүйлийн тодорхойлолт	Төсөвт өртөг /сая төгрөг/	Ажлын тоо хэмжээ
1	Аргаль уриа ДДТ-1 өргөтгөл	Зураг төсөл боловсруулах "Барих-шилжүүлэх"	Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр 1-р хэлхээний 194 метр 2 хос шугам, 2-р хэлхээний 220 метр, 5 хос шугам сүлжээ өргөтгөж аймгийн өмчид шилжүүлнэ.	335.9	<ul style="list-style-type: none"> <li>➢ 240 м 2-р хэлхээний 5 хос шугам шинээр татах</li> <li>➢ 1-р хэлхээний 194 м 3 хос шугам татах</li> </ul>
2	Жаргалант сумын 10 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Зураг төсөл боловсруулах "Барих-шилжүүлэх"	Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр цэцэрлэг барьж аймгийн өмчид шилжүүлнэ.	200.0	<ul style="list-style-type: none"> <li>➢ 24*12 харьцаатай 288 м.квадрат талбайтай 1 давхар 13 өрөө бүхий тоосгон барилга,</li> </ul>
3	Аймгийн төвийн бохир усны хуучин шугам шинэчлэх, өргөтгөх	"Барих-шилжүүлэх"	Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр аймгийн төвийн бохир усны хуучин шугам шинэчлэх, өргөтгөх өмчид шилжүүлнэ.	496.2	<ul style="list-style-type: none"> <li>➢ Жаргалант сумын бохирын шугам сүлжээний хойд чиглэл буюу Буянт баг, Нэгдсэн эмнэлгийн чиглэлээс хуримтлагдсан бохирыг Цамбагарав багийн ахмадын байрны дээд хэсгийн худгаас 36 айлын чиглэлд дайран өнгөрч КНС-ын худгагт цутгах нийт 3000 м бохирын шугамын нэвтрэх чадварыг сайжруулан хос 500 мм голчтой шугам тавих</li> <li>➢ Жаргалант багийн 24 айлын ард талын худгийг 2-60 айлын худгаг хооронд шинээр 500м шугам хийж, Ховд хотын</li> </ul>

				<p>Бохирын шугам сүлжээний кольцо үүсгэх.</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Жаргалант сумын урд чиглэл буюу дулааны Бадамлах дөл ХК-ний урд худаас хүнсний үйлдвэрийн чиглэлийн 1250 м шугамыг 500мм голчтой хоолойгоор солих</li> </ul>	
4	Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөл	"Барих-шилжүүлэх"	Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр эрүүл мэндийн төвийн өргөтгөл барьж аймгийн өмчид шилжүүлнэ.	200.0	<ul style="list-style-type: none"> <li>➢ 288 м.квадрат ашигтай талбайтай, 12 өрөө бүхий 1 давхар тоосгон барилга, гадна талбайн 96 м.квадрат, 150м цэвэр усны шугам хоолой, 500м-ээс 380 вольтын цахилгаан татах</li> </ul>
5	Галданбошгот хааны нэрэмжит гудамжийг тохижуулж дуусгах	"Барих-шилжүүлэх"	Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр Галданбошгот хааны гудамжийг тохижилтийг иж бүрнээр хийж аймгийн өмчид шилжүүлнэ.	261.5	<ul style="list-style-type: none"> <li>➢ Явган хүний замын хучилтыг чулуугаар хийх 4014 м.квадрат</li> <li>➢ Цэцгийн мандал чулуугаар өрөх 4.06 м.куб</li> <li>➢ Чулуун өнгөлгөө хийх 6 м.квадрат</li> <li>➢ Цэцгийн мандал доорх хар шороог хийх 39 м.квадрат</li> <li>➢ Цэцгийн мандалд зүлэг суулгах 262 м.квадрат</li> <li>➢ Хайрган дэвсгэр үе хийх 26.2 м.куб</li> <li>➢ Бетон суурь цутгах 8.8 м.куб</li> </ul>
6	Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэгийн барилгын өргөтгөл	"Зураг төсөл боловсруулах" "Барих-шилжүүлэх"	Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр цэцэрлэг барьж аймгийн өмчид шилжүүлнэ.	200.0	<ul style="list-style-type: none"> <li>➢ 24*12 харьцаатай 288 м.квадрат тайлбайтай 1 давхар 13 өрөө бүхий тоосгон барилга</li> </ul>
7	Тахилт багт 50-100 хүүхдийн цэцэрлэг	"Зураг төсөл боловсруулах" "Барих-ашиглах"	Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр тахилт багт 50-100 хүүхдийн цэцэрлэг барьж ашиглах	200.0	<ul style="list-style-type: none"> <li>➢ 24*12 харьцаатай 288 м.квадрат тайлбайтай 1 давхар 13 өрөө бүхий тоосгон барилга</li> </ul>
8	Сумдын төвийн албан байгууллага,	Барих-ашиглах-шилжүүлэх	Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр Орчин үеийн	876.1 Сумын орон	<ul style="list-style-type: none"> <li>➢ Алтай сумын айл өрх албан байгууллагуудыг холбосон нэгдсэн халаалтын систем</li> </ul>

	айл өрхүүдийг холбосон нэгдсэн халаалтын систем /Алтай сум /		дэвшилтэт технологийн зуух суурилуулах, байгууллага, айл өрхүүдийг холбосон шугам сүлжээ байгуулж, ашиглаж сумын өмчид шилжүүлнэ.	нутгийн хөгжлийн сангаас 150,0 гаргуулах аар тогтов	
9	52 айлын орон сууц ДДТ-2-с 80 айл чиглэлийн дулааны шугам татах	Зураг төсөл боловсруулах "Барих-шилжүүлэх"	Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр 6-8МВт-аар ДДТ-2-ыг шинэчлэн, 1-р хэлхээний 2 хос 49 метр шугам өргөтгөж, 2-р хэлхээний 315 метр 5 хос шугам сүлжээ шинээр барьж аймгийн өмчид шилжүүлнэ.	515.5	<ul style="list-style-type: none"> <li>➢ 52-ын Дулаан дамжуулах төвийн хүчин чадлыг нэмэгдүүлж 6-8 мВт-ын өргөтгөл шинэчлэл хийх <ul style="list-style-type: none"> <li>➢ 1-р хэлхээний 49 м шугам өргөтгөх</li> <li>➢ 2-р хэлхээний 315 м 5 хос шугам өргөтгөх</li> </ul> </li> </ul>
10	Жаргалант сумын 3 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Зураг төсөв боловсруулах "Барих-шилжүүлэх"	Концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр цэцэрлэг барьж аймгийн өмчид шилжүүлнэ.	200.0	<ul style="list-style-type: none"> <li>➢ 15*9 харьцаатай 270 м.квадрат тайлбайтай 2 давхар 12 өрөө бүхий тоосгон барилга</li> </ul>



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 25

Ховд

Эмчилгээний зардалд дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Буянт сумын харъяат Батбаяр овогтой Энхтайван нь магадлан итгэмжлэл бүхий Хавдар судлалын Үндэсний төв эмнэлгийн шийдвэрээр Солонгос улсад Ходоодны хорт хавдрын мэс засал хийлгэж, эмчлүүлэх шаардлагатай болсон тул эмчилгээний зардалд 2000000 төгрөг /хоёр сая/-ийн нэг удаагийн тусламж дэмжлэг үзүүлсүгэй.

2. Иргэн Б.Энхтайваны эмчилгээний зардалд олгох 2000000 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2016 оны батлагдсан нөөц хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН





ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 26

Ховд

“Сургуулийн цагдаа” эргүүлийн ажиллах  
журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтуудыг үндэслэн аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сургуулийн орчинд үүрэг гүйцэтгэх “Сургуулийн цагдаа” эргүүлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 27

Ховд

Бага оврын трактор гэрээлэн  
авах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дэх заалтыг үндэслэн аймгийн Засаг даргын саналыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хадлан, тэжээлийн нөөц бүрдүүлэхэд техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас аймгуудад нийлүүлэгдэж байгаа бага оврын 46 тракторыг гэрээлэн авахыг зөвшөөрсүгэй.

2. Гэрээлэн авсан бага оврын тракторыг иргэд, аж ахуйн нэгжид үнийг нь орон нутгийн хөгжлийн сангаас 4 жилд тэнцүү хувааж буцаан төвлөрүүлэх журмыг баримтлан хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Цэвээнравдан/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 28

Ховд

Зөвшөөрөл сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Жаргалан багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Хаанчлалын сайн мэдээг тунхаглагчид” шашины байгууллагын үйл ажиллагаа явуулах эрхийг 2017 оны 03 дугаар сарын 23-ний өдрийг хүртэл 1 жилийн хугацаатайгаар сунгасугай.

2. Үйл ажиллагаандаа “Ховд аймгийн нутаг дэвсгэрт Шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-ыг удирдлага болгон ажиллахыг “Хаанчлалын сайн мэдээг тунхаглагчид” сүмийн тэргүүн /Л.Элбэгсайхан/-д зөвлөсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 30

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Цэргийн гавъяаны улаан тугийн одон”-гоор

1. Аюуш Эрдэнэчулуун - Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга

“Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор

1. Самбуу Лхагважав - Жаргалант сумын Магсаржав багийн ахмад настан
2. Лхамцэрэн Дамдинжамц - Ховд сумын Баруун салаа багийн ахмад настан

“Цэргийн гавъяаны одон”-гоор

1. Норзон Тэрбиш - Жаргалант сумын Жаргалан багийн иргэн

“Алтан гадас одон”-гоор

1. Муратай Бердихан - Ховд сумын Цагаанбургас багийн иргэн
2. Баасай Цэгмид - Манхан сумын Раашгонзиглэн хийдийн гэгцэл лам

- |                       |  |
|-----------------------|--|
| 3. Жанчив Дархижав    | - Аймгийн ЗДТГ-ын бичээч операторч                       |
| 4. Наранхүү Пүрэвдорж | - Чандмань сумын Сүлжээ багийн малчин                    |
| 5. Дашдорж Нохойжав   | - Чандмань сумын Сүлжээ багийн малчин                    |
| 6. Дэлэгням Батдэлгэр | - “Алтай Трест” ХХК-ний хүнд даацын<br>автомашины жолооч |
| 7. Домысхан Жолды     | - Ховд сумын ЗДТГ-ын Санхүү албаны дарга                 |
| 8. Дүгэрсүрэн Батням  | - Дөргөн сумын УЦС ХХК-ний гидро<br>механикийн инженер   |
| 9. Баатар Цэнгэл      | - Мөнххайрхан сумын ИТХ-ын дарга                         |
| 10. Наранхүү Бямба    | - Чандмань сумын Сүлжээ багийн малчин                    |
| 11. Мэндээ Өлзийхүү   | - “Ховд Мөнх түшиг” ХХК-ний захирал                      |
| 12. Дандар Тотоо      | - Буянт сумын Цагаан эрэг багийн иргэн                   |
| 13. Ноосонбор Дамбий  | - Үенч сумын ахмад настан                                |

“Цэргийн хүндэт медаль”-иар

- |                      |   |
|----------------------|---|
| 1. Бугалжаа Баттулга | - Аймгийн Цагдаагийн газрын ахмад ажилтан                   |
| 2. Шарав Гантулга    | - Аймгийн Цагдаагийн газрын ахмад ажилтан                   |
| 3. Даваа Мөнхжаргал  | - Аймгийн Цагдаагийн газрын Архив, бичиг<br>хэргийн эрхлэгч |

“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар

- |                        |  |
|------------------------|--|
| 1. Өсөхбаяр Цэдэнбал   | - Жаргалант сумын Магсаржав багийн иргэн                   |
| 2. Нацаг Дамдиндорж    | - Дуут сумын 12 жилийн сургуулийн<br>хөгжмийн багш         |
| 3. Цэвээн Цэрэнгомбо   | - ХИС-ийн Физикийн тэнхмийн багш                           |
| 4. Лхагва Орломсүрэн   | - ХИС-ийн үйлчлэгч   |
| 5. Гүрбазар Цэцэгсүрэн | - Жаргалант сумын 12 жилийн сургуулийн<br>бага ангийн багш |
| 6. Ахмет Аман          | - Буянт сумын Цагаан Эрэг багийн малчин                    |

- 7. Көпөс Аманбай
- 8. Энгэч Батжаргал
- 9. Цэндээ Дагвасүрэн

- Ховд сумын Баянбулаг багийн малчин
- Буянт сумын Цагаанбургас багийн иргэн
- Буянт сумын Цагаан эрэг багийн малчин

ХУРЛЫН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 31

Ховд

Нийтийн дуудлага худалдаа  
дахин зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн хөрөнгийг худалдах, дуудлага худалдааг зохион байгуулах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэхь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны нийтийн дуудлага худалдаа зарлах тухай 51, 71 дүгээр тогтоолоор худалдан борлогдоогүй Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн, сумдад хадгалагдаж буй дизель цахилгаан моторуудын дахин нийтийн дуудлага худалдаагаар худалдах доод үнийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн дуудлага худалдааг 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр аймгийн Нутгийн удирдлагын ордонд зохион байгуулсугай.

3. Хавсралтанд тусгагдсан хөрөнгийн борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн, түүний 40,0 /дөч/ хүртэлх хувийг хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, чанар байдлыг харгалзан тухайн сумдын төсвийн орлогод шилжүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга /Б.Баярсайхан/-д зөвшөөрсүгэй.

4. Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын албаны эдийн засаг, үйлдвэрлэл, өмчийн харилцааны хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны  
31 дүгээр тогтоолын хавсралт



ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Эзэмшигч байгууллага	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Худалдах доод үнэ
1	Алтай сумын Засаг даргын Тамгын газар	Камацу-60 мотор	1998	ш	2	2020.0	4040.0	4040.0	0.0	48000.0
2	Булган сумын Засаг даргын Тамгын газар	Камацу-100 мотор	1998	ш	3	4016.0	12048.0	12048.0	0.0	
3	Үенч сумын Засаг даргын Тамгын газар	Камацу-60 мотор	2002	ш	2	3654.0	7308.0	7308.0	0.0	
4	Цэцэг сумын Засаг даргын Тамгын газар	Камацу-60 мотор	1999	ш	3	3654.2	10962.6	10962.6	0.0	
5	Дуут сумын Засаг даргын Тамгын газар	Камацу-60 мотор	2002	ш	2	3654.2	7308.4	7308.4	0.0	
6	Мөнххайрхан сумын Засаг даргын Тамгын газар	Камацу-100 мотор	1999	ш	2	4016.0	8032.0	8032.0	0.0	32000.0
7	Дөргөн сумын Засаг даргын Тамгын газар	Камацу-60 мотор	2000	ш	1	3654.2	3654.2	3654.2	0.0	
8	Зэрэг сумын Засаг даргын Тамгын газар	Камацу-60 мотор	1999	ш	2	3654.2	7308.4	7308.4	0.0	
9	Чандмань сумын Засаг даргын Тамгын газар	Камацу-60 мотор	1999	ш	2	3654.2	7308.4	7308.4	0.0	
10	Манхан сумын Засаг даргын Тамгын газар	Камацу-100 мотор	2002	ш	1	4016.0	4016.0	4016.0	0.0	
<b>НИЙТ ДҮН</b>					<b>20</b>		<b>71986.0</b>	<b>71986.0</b>	<b>0.0</b>	<b>80000.0</b>

.....оо.....